

Өмнөх үг

2020 он Ковид-19 цар тахлын аюул, эрсдэл дунд өнгөржээ. Олон жилийн өмнөөс эрдэмтэд амьтны гаралтай өвчин үүсгэгч нэмэгдэж байгааг онцолж, Ковид-19 шиг цар тахал дэгдэж болзошгүйг анхааруулж байсан билээ. Энэ цар тахал хүмүүс бидний эх дэлхийдээ учруулсаар ирсэн дарамтын нэгэн тусгал юм.

Эх дэлхийд учруулж буй бидний дарамт сүүлийн 100 жилд хурдацтай нэмэгдэж ирсэн. Хүн төрөлхтөн гайхалтай амжилтанд хүрсэн ч, эх дэлхийгээ аюулын ирмэгт авчирчээ. Уур амьсгалын өөрчлөлт, тэгш бус байдал, хямрал, мөргөлдөөний улмаас орон гэрээсээ дайжихад хүрсэн хүний тоо зэрэг асуудлууд байсаар байна. Энэ бүхэн үнэ цэнэтэй зүйлээ хэмжихийн оронд, хэмжиж болдог зүйлд үнэ цэнэ өгдөг нийгийн тогтолцооны үр дүн юм.

Үнэндээ бидний гараг дэлхийдээ өгч буй дарамт дэндүү их болж, эрдэмтэд дэлхий дээр Антропоцен буюу хүн төрөлхтөн эх дэлхийгээ өөрчилж буй эрин үе гэх геологийн шинэ эрин үе эхэлсэн гэж үзэх болжээ. Өөрөөр хэлбэл бидний оршин тогтнолын хамгийн том эрсдэл нь бид өөрсдөө болж хувирсан, хүний сонголтоор тодорхойлогдох эрин үед амьдарч буй эхний хүмүүс бид болж байна.

Ийнхүү байгаль дэлхийд үзүүлж буй хүн төрөлхтөний дарамтыг үгүй болгохын зэрэгцээ хүний хөгжлийг ахиулах нь хүний хөгжлийн шинэ сорил болох бөгөөд НҮБХХ-ийн Хүний Хөгжлийн Илтгэлийн 30 жилийн ойг тохиолдуулан гаргасан энэхүү илтгэлийн гол сэдэв болж байна.

Энэ шинэ эринд амжилттайгаар хөгжихийн тулд бид хөгжил дэвшлийн замналаа шинээр зураглах ёстой болох бөгөөд үүнд хүн ба эх дэлхийн нягт уялдаа холбоог хүндэтгэж, чинээлэг хүмүүсийн экологийн ул мөр болон материалын хэрэглээ нь ядуу, буурай хүмүүсийн боломжийг хязгаарлаж байгааг ойлгох хэрэгтэй юм.

Тухайлбал, дэлхийн халуун орны ойн дийлэнх болох Амазонд байгаль дэлхийтэйгээ зөв зохистой харьцан амьдарч буй нэгэн уугуул иргэний үйл хэрэг дэлхийн хамгийн баян 1%-ын төлөөлөл болсон нэгэн хүний ялгаруулсан нүүрстөрөгчийн хувь хэмжээг дүйцүүлэн саармагжуулж байдаг. Гэтэл, уугуул иргэд янз бүрийн бэрхшээл, шийтгэл, ялгаварлалд өртсөөр байна.

Аж Үйлдвэрийн Хувьсгалаас хойш өнөөг хүртэл ялгарсан нүүрстөрөгчийн давхар исэл манай гаригийн агаар мандлаас бүрэн замхрах хүртэл нэг хүний дөрвөн мянган үе улирахтай тэнцэх хугацаа өнгөрнө гэх тооцоо бий. Гэсэн хэдий ч, шийдвэр гаргагчид шатах ашигт малтмалыг төрөл бүрийн хөнгөлөлт татаасаар дэмжиж, эдийн засгийн эргэлдэх судсаар хар тамхи шахах мэт нүүрстөрөгч ялгаруулдаг дадлыг хөхүүлэн дэмжсээр байна.

Бидний энэ амьдрах хугацаанд дэлхийн хамгийн чинээлэг орнуудад цаг уурын хямралаас улбаатай онц үзэгдэл бүхий өдөр жилд 18-аар цөөн тохиолдох бол, хамгийн ядуу буурай орнуудад жилд 100-аар илүү тохиолдох төлөвтэй байна. Энэ тоог Парисын Хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлч чадвал хоёр дахин бууруулж чадах юм.

Өөрчлөлт хийх цаг иржээ. Бидний ирээдүй бол хүн, мод хоёрын аль нэгийг сонгох тухай асуудал биш. Хоёуланг нь сонгохоос өөр гарцгүй юм.

Анх 1990 онд Хүний Хөгжлийн Илтгэлээр дамжуулан хөгжил дэвшил гэдгийг зөвхөн эдийн засгийн үзүүлэлтээр хэмжих нь учир дутагдалтай гэдгийг онцлон гаргаж тавьсан байдаг. Тэр үед Хүйтэн Дайн геополитикт нөлөөлсөн хэвээр, интернэтийг дөнгөж зохион бүтээсэн бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн талаар маш цөөн хүн мэдэж, сонссон байсан юм. Тэр үед НҮБХХ-өөс ДНБ-ээс өөр хувилбар болох ирээдүйг харсан хэмжүүрийг санал болгож, иргэддээ олгож буй эрх чөлөө хийгээд боломжоор нь улс орнуудыг эрэмбэлсэн билээ. Ийнхүү бид сайн сайхан амьдралын утга учир, түүнд хүрэх арга замуудын талаарх хэлэлцүүлгүүд шинээр төрөх шанг татсан байдаг.

Үүнээс хойш 30 жил өнгөрөхөд олон зүйл өөрчлөгдсөн ч, итгэл найдвар, боломж хоёр өөрчлөгдөөгүй. Хүн төрөлхтөн геологийн цоо шинэ эрин үеийг бий болгох хүч чадалтай юм бол, өөрчлөлтийг сонгох ч чадалтай гэсэн үг. Бид Антропоценийн эрин үед амьдарч буй хүмүүсийн сүүлийн үе биш. Харин түүнийг таньж мэдсэн эхний үеийн хүмүүс юм. Бид бол судлаачид, шинийг санаачлагчид - Антропоценийн эрин үед хэрхэн амьдрах вэ гэдгийг бүтээлчээр шийдэж чадсанаараа түүхэнд бичигдэх эхний үеийн хүмүүс.

Хуванцар шүдний сойз болон ундааны тагнуудтай хамт намаг балчигт шигдэн чулуужих олон зүйлийн мөхсөн амьтдын ул мөр, хог хаягдал, хохирол сүйрлээрээ бид түүхэнд бичигдэх үү? Эсвэл илүү үнэ цэнтэй өв уламжлал буюу хүн төрөлхтөн эх дэлхийтэйгээ тэнцвэртэй амьдарч эхэлсэн, тэгш, шударга ирээдүйг хойч үедээ үлдээх үү?

Шинэ эрин: Хүний хөгжил ба Антропоценийн үе гэж нэрлэсэн энэхүү илтгэлээр тус сонголтыг тодорхойлж, өсөн нэмэгдэж буй ядуурал, тэгш бус байдал болон эх дэлхийн аюул дохиолсон өөрчлөлтийн өмнө балмагдан зогсохын оронд өөрчлөгдөх арга зам хайн, ухаан бодлоо уралдуулан сонгох хөгжлийн шинэ хувилбарыг санал болгож байна. Энэхүү илтгэлд санал болгож буй Эх дэлхийдээ өгч буй Дарамтыг Тооцсон Хүний Хөгжлийн индекс гэх шинэ бөгөөд туршилтын индекс нь улс орон бүрийн хувьд хараахан судлагдаагүй байсан цаашдын замналыг санал болгож, шинэ хэлэлцүүлгүүд эхлүүлнэ гэж бид итгэж байна. Ковид-19 цар тахлын дараах ирээдүй хүн төрөлхтөний хувьд гайхалтай аялал байх болно. Энэ аянд хүн бүр хамтдаа явахаар сонгоно гэдэгт бид итгэлтэй байна.



Аким Штайнер

Захирагч

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

ХУРААНГУЙ

Хүний Хөгжил ба Антропоцений үе

Хүний Хөгжил ба Антропоцений үе

2020 оны Хүний Хөгжлийн Илтгэлийн бүтэц



Бид хүн төрөлхтний түүхэнд ч, гараг дэлхийн түүхэнд ч урьд өмнө нь байгаагүй шинэ цагийн босгон дээр ирээд байна. Бидний нийгэм хийгээд эх дэлхийгээс өгч буй анхааруулах гэрэл улаанаар анивчаад удаж байгааг бид сайн мэднэ. Өргөн тархсан тэнцвэргүй байдлын хамгийн сүүлийн үеийн хор уршиг Ковид-19 цар тахлаар илэрч байна. Эрдэмтэд олон жилийн турш хүн, амьтан, зэрлэг байгалийн харилцааны¹ цар хүрээ, хурд нэмэгдсээр, эцэстээ экосистемүүдэд асар их дарамт үүсгэж, шинэ төрлийн өвчин үүсгэгч вирус дэгдэнэ хэмээн анхааруулж байсан билээ. Шинэ төрлийн коронавирус үүний нэг жишээ бөгөөд бид байгальтайгаа дур зоргоор харьцахаа болиогүй цагт энэ мэт хямрал дахин давтагдах нь гарцаагүй юм.


Шинэ өвчин үүсгэгч бичил организм болон түүнээс улбаатай тахал нь гэнэт хийсээд ирдэг юм биш. Ковид-19 цар тахал харилцан нягт холбоотой дэлхий ертөнцөд түргэн тархаж, нийгмийн хамгийн эмзэг тал дээр дөрөөлөн дэгдэж, хүний хөгжлийн олон талт тэгш бус байдлаас улбаалан очсон газар бүрдээ голомт үүсгэж, эргээд энэ нь уг тэгш бус байдлыг улам бүр хурцатгаж байна. Хамгийн харамсалтай нь нийгмийн эмзэг болон эрсдэлтэй талууд нь эргээд эл вирусийг хяналтад оруулах хүчин чармайлтыг үр дүнгүй болгож байна (2-р бүлэг).

Дэлхий даяар Ковид-19 цар тахалд анхаарлаа хандуулсан хэдий ч, өмнө нь байсан хямралууд үргэлжилсээр байгааг мартаж болохгүй. Жишээ нь, Уур амьсгалын өөрчлөлт, 2020 оны Атлантын хар салхины улиралд дэгдсэн шуурганы тоо болон эрчим нь урьд хожид байгаагүй хэмжээнд хүрсэн гэж хэлж болно.² Сүүлийн 12 сард Австралийн хээр тал, Бразилын Пантанал, ОХУ-ын Дорнод Сибирь, АНУ-ын Баруун Эрэгт асар хүчтэй ой хээрийн түймэр дэгдлээ.³ Эх дэлхийн биологийн олон янз байдал хумигдаж, биологийн төрөл зүйлсийн дөрөвний нэг нь мөхлийн ирмэгт ирж, ирэх хэдэн арван жилд илүү олон төрөл зүйл мөхөх эрсдэлтэй байна.⁴ Олон эрдэмтэд хүн төрөлхтний нөлөөгөөр биологийн үй олон төрөл зүйл мөхөж буй эрин үед эсвэл ийм эрсдэл бүхий цаг үеийн хаяанд аж төрж байна гэж үздэг бөгөөд ийм аюул эрсдэл гараг дэлхийн түүхэнд зургаа дахиа тохиолдож буй боловч анх удаа цорын ганц амьд организм буюу хүний нөлөөнөөс бий болж байна.⁵

“ Нийгэм хийгээд эх дэлхийд өгч буй анхааруулах гэрэл улаанаар анивчиж байна.

Эх дэлхийд маань учраад буй энэхүү дарамт нь олон улс оронуудад учирч буй сорилтуудын толин тусгал юм. Энэ бол ердийн давхцал биш.

Зураг 1 Байгаль эх дэлхийн болон нийгмийн тэнцвэргүй байдал харилцан нэг нэгнээ даамжруулж байгаа нь




Эх сурвалж: Хүний Хөгжлийн Илтгэлийн Алба (ХХИА).

Мэдээж, гараг дэлхийн тэнцвэргүй байдал (хүмүүс болон амьдралын бүхий л хэлбэрт аюул учруулж буй гараг дэлхийн өөрчлөлт), нийгмийн тэнцвэргүй байдал хоёр харилцан нөлөөнд оршиж улам бүр даамжирсаар байна (зураг 1).⁶ 2019 оны Хүний Хөгжлийн Илтгэлд тодорхой өгүүлсэнчлэн хүний хөгжлийн замналд олон талт тэгш бус байдал өссөөр байгаа бөгөөд цаашид ч өсөх тооцоо байна.⁷ Байгаль дэлхийн олон аюулт өөрчлөлтийн дундаас Уур амьсгалын өөрчлөлт уг тэгш бус байдлыг улам дордуулахаар байна (зураг 2).⁸ Нийгмийн бүлгүүдийн нөхцөл байдал доройтож, нийгмийн тогтворгүй байдал нэмэгджээ.⁹ Ардчилал ухарч, авторитар дэглэм ихсэх төлөв байдал түгшүүр төрүүлж байна.¹⁰ Нийгмийн хуваагдал их байгаа энэ нөхцөлд Ковид-19 цар тахлаас авхуулаад Уур амьсгалын өөрчлөлт хүртэлх аливаа асуудалд нэгдмэл арга хэмжээ авахад улам бүр хэцүү болж байна (1-р бүлэг).¹¹

“Шинэ хэв маяг тогтох болно. Ковид-19 бол зөвхөн эхлэл.

Цар тахлын дараа эргээд “хэвийн байдалдаа” орох тухай яриа хэлэлцүүлэг өрнөж, үүнд нийгэм, эх дэлхийд учирсан олон хямралд дуусах өдөр шууд оноогдсон байдаг юм шиг, хөгжлийн хуучин хэв загвартаа эргэн орох нь сайн эсвэл бүр боломжтой зүйл юм шиг хэлэлцэх боллоо. Уг хэвийн байдал гэгч нь ямархуу байх вэ, эсвэл хэний хэвийн байдал, хэв загвар байх вэ? Хямралаас хямрал хооронд арай ядан явах нь өнөө цагийн нэгэн шинж чанар болжээ.

Зураг 2 Уур амьсгалын өөрчлөлтийн нэгэн үр дүн болох цаг агаарын хэт хэлбэлзэлтэй өдрүүдийн тоо нэмэгдэх нь хүний хөгжлийн тэгш бус байдлыг улам дордуулна



ӨЗЗ/РСР: Өтгөрөлтийн Загвар Зам/Representative Concentration Pathway.

Жич: Агаарын хэм цельсийн 0 хэмээс доош унах эсвэл цельсийн 35 хэмээс дээш өсөх өдрүүдийг агаарын онцгой хэмт өдөр гэнэ. Зурагт 1986-2005 оны хоорондох агаарын онцгой хэмт өдрийн тоог 2080-2099 оны хоорондох агаарын онцгой хэмт өдрийн тооны дундаж таамагтай харьцуулан харуулав.

Эх Сурвалж: Carleton нарын эх сурвалжид үндэслэн Хүний Хөгжлийн Илтгэлийн Албанаас (ХХИА) мэдээлэв (2020).

Гэвч нүүрстөрөгчийн татаас нь үнэндээ нүүрстөрөгчийн ялгаруулалтыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ байдлыг нэгэнт халах цаг нь болсон гэдгийг бид мэднэ (5-р бүлэг). Энэ Илтгэлд улс орнууд шинэ сонголт хийж болох янз бүрийн аргуудын тухай өгүүлэх боловч, хамгийн гол нь байгаль, эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулангаа хүний хөгжлийг урагшлуулах үйл явцад тулгарах бэрхшээлүүдийг илүү нарийн тодорхойлохыг зорьсон юм. Мөн зарим нэг нийгэмд нилээд ихээр хэлэлцэн тодорхойлсон “шийдлүүд” яагаад бүрэн хэрэгжихгүй байгааг, хэрэгжлээ ч ихэнхдээ яагаад өөрчлөлтийг авчрах цар хүрээнд хэрэгжихгүй байгааг онцлон судалсан.

Энэхүү илтгэлд “нэг асуудалд шийдэл олох” гэдэг хандлага аргачилалд бүхэлд нь шүүмжлэлтэй хандаж байгаа бөгөөд зөвхөн нэг асуудлыг тойрон шийдлүүд гаргах нь өөрөө бидэнд тулгарч буй асуудлуудыг өөр хоорондоо уялдаа холбоогүй салангид оршин байдаг мэт болгож цогц шийдэл гаргах боломжгүй болгож байна. Мөн шийдлийг нь олсон хойно дэлхий даяар хэрэгжүүлээд бүх асуудлыг нэг мөр арилгана гэж итгэдэг байдлыг шүүмжлэн тусгасан. Технологи болон инновац чухал. Маш чухал. Гэхдээ асуудлуудыг том зургаар нь харвал маш нарийн, шугаман бус, асар хувьсамтгай бөгөөд “залгаад л тоглуулна” гэх хуучны энгийн хандлага огт тохирохгүй юм. Найдвар төрүүлсэн, цор ганц сайн шийдэл нь санамсаргүй бөгөөд аюулт үр дагаврыг авчирч болно.


Бид салангид, дангаар орших асуудлуудыг шийдвэрлэхээс илүүтэй, олон хэмжээст, харилцан нягт уялдаатай, дэлхий дахиныг хамарсан хүнд бэрх асуудлуудыг шийдвэрлэх чиглэлд хандлагаа өөрчлөх ёстой.

Нарийн төвөгтэй энэ цаг үед, “хийх явцдаа суралцах” уян хатан чанартай, олон төрлийн инновацад түшиглэсэн, хамтарсан шийдвэр гаргах явдлыг эн тэргүүнд чухалчилсан, урамшуулал, дэмжлэгийг зохих хэмжээнд ашигласан байдлаар ахиц дэвшлийг авчрах ёстой. Гэхдээ дэвшил өөрчлөлтийг хийхэд амаргүй байх болно. Ашиг сонирхлын их ялгаа байгаагийн дээр одоогийн институцүүдийн хариу арга хэмжээ авах байдал болон эгэх хариуцлага өөр хоорондоо асар их ялгаатай байна. Түүнчлэн олон төрлийн тэгш бус байдлын улмаас шийдвэр гаргалтад оролцох боломж хязгаарлагдаж, инновац гарах боломж хумигдаж, уур амьсгалын өөрчлөлт болон экологийн аюулд өртөх эрсдэл нэмэгдэж байна (зураг 3).¹³ Хөгжлийн сонголтуудыг явцуу, сайн танигдсан, гэвч эцэстээ тогтворгүй байдал үүсгэх өнцгөөс авч үзэж байна. Гэхдээ хамгийн гол нь бид юунд хэр их үнэ цэн өгч байна вэ гэдэг чухал нь юм.¹⁴

“Үнэт зүйлс болон институцүүдийн нөлөөнд хийсэн хүн төрөлхтний сонголтууд нь өнөө бидний өмнө тулгамдаад буй эх дэлхий болон нийгмийн тэнцвэргүй байдлыг бий болгожээ. Энэ тэнцвэргүй байдал нь өөр хоорондоо харилцан уялдаатай юм.

Шекспирийн *Юлий Цезарь* жүжигт Кассиус, “Алдаа... бидний одод биш-Бидэнд өөрсдөд маань байна”¹⁵ гэж хэлдэг.

Зураг 3 Экологийн аюул ихтэй улс орнуудад нийгмийн эмзэг байдал мөн өндөр байна



Жич: Хэт ялгаатай утгыг энд эс тооцов. Экологийн аюул гэдэгт усны хомстол, хүнсний аюулгүй байдал алдагдах, ган, үер, хар салхи, агаарын хэмийн өсөлт, далайн түвшний нэмэгдэлт болон хүн амын өсөлт орно. Аюулын түвшинг улс орон бүрд тулгарч буй аюулын тоогоор тодорхойлно: бага (0-1 аюул), дунд (2-3 аюул), өндөр (4-өөс олон аюул) Эдийн Засаг ба Энх Тайвны Хүрээлэнгийн (ЭЗЭТХ) эх сурвалжийг (2020) үзнэ үү.

Эх сурвалж: НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөл болон ЭЗЭТХ-ийн өгөгдөлд үндэслэн ХХИА-аас мэдээлэв (2020).

Ухамсартай ч бай, үгүй ч бай, үнэт зүйлс болон институцүүдийн нөлөөнд хийсэн хүн төрөлхтний сонголтууд нь өнөө бидний өмнө тулгамдаад буй эх дэлхий болон нийгмийн харилцан уялдаатай тэнцвэргүй байдлыг бий болгожээ. Түүнийг ойлгож, шийдвэрлэх замд мөн л өнөөх үнэт зүйлс болон институцүүдийн бидний өнгөрсөн сонголтуудад нөлөөлж ирсэн тэр хөшүүн байдал саад болж байна. 2030 он хүртэлх хүмүүс болон эх дэлхийн Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын хэрэгжилтийг хурдасгахын тулд бид хүний үнэт зүйлс болон институцүүдийн асуудлын гол цөмд орж шинжлэх, тэр дундаа эрх мэдлийн хуваарилалт, ашиглалтын сул талыг ул суурьтай шинжлэх ёстой.

Аюул дохиолж буй байгаль дэлхийн өөрчлөлтийн өмнө бүх нийтээрээ идэвхтэй үйлдэл хийж чадахгүй байгаа энэ байдлыг өөрчлөхөд хүний хөгжлийн аргачлал их тус болно. Хүний хөгжил бол хүмүүст ганц, хоёр тодорхой зам зааж өгөхөөс илүүтэй, өөрсдийн ялгаатай үнэт зүйлсэд хөтлөгдөн өөрсдийн гэсэн хөгжлийн замаа гаргахад хэрэгтэй эрх чөлөө, сонголтуудыг нэмэгдүүлэхийн нэр юм. Хөгжлийн сонголтууд хүн мод хоёрын аль нэгийг сонгох тухай байх нь элбэг. Энэ нь өнгөрсөн үед эдийн засгийн өсөлтийг эн тэргүүнд тавьж, байгаль орчныг бүх шатанд доогуур үнэлж ирсэнтэй холбоотой юм. Хөгжлийн энэ харалган тодорхойлолтыг өөрчлөх зорилгоор 30 жилийн өмнөөс хүний хөгжил гэх ойлголтыг гаргаж ирсэн билээ. Эдийн засгийн өсөлт ялангуяа хөгжиж байгаа орнуудад чухал. Ямар ч орны хувьд ядуу иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх нь чухал. Гэвч 2019 оны Хүний Хөгжлийн Илтгэлээр олон орны хувьд бялуугаа томруулах нь бус, бялууныхаа хуваалтыг тэгш болгох нь илүү чухал гэдгийг онцлон гаргаж ирсэн.¹⁶ Энэ жилийн Илтгэлээр бид түүхэндээ анх удаа бялуу хийх зуухандаа санаа зовниж эхэлж байна.

Эдийн засгийн өсөлт нь эцсийн зорилго бус, харин арга хэрэгсэл юм гэдгийг хүний хөгжлийн аргачлал бидэнд сануулдаг. Эх дэлхийнхээ хязгаарыг бодолцон, тэгш хуваарилж байгаа үед материалын нөөц их байх тусмаа хэрэгтэй.¹⁷ Учир нь материалын нөөц үеэс үед хүмүүсийн боломжийг олшруулдаг. Мэдээж, анхны Хүний Хөгжлийн Индексийн (ХХИ) орлогын бүрэлдэхүүн нь хүмүүсийн боломжийг олшруулдаг үндсэн чадавхын багцыг бий болгох материалын нөөцийг хэмжих үүрэгтэй байсан. Эрүүл амьдралаар амьдрах болон боловсрол эзэмших гэсэн хоёр чадавх нь ийм ач холбогдолтой байсан учраас ХХИ-ийг тооцож эхэлсэн цагаас бүрэлдэхүүнд нь орж ирсэн юм. Орлого эсвэл эдийн засгийн өсөлтөөс ялгаатай нь, эдгээр үзүүлэлтүүд бол хэрэгсэл төдий биш, харин эцсийн зорилго юм.

2019 оны Хүний Хөгжлийн Илтгэлд хүмүүс дижитал эринд аж төрөхөд, илүү чадавхажсан шинэ үеийнхэн чухал хэрэгтэй болж байгаа талаар онцолсон.¹⁸


Хүний хөгжлийн суурь зарчмууд өөрчлөгдөөгүй. Тэдгээрийн гол чиг баримжааг хүмүүс өдгөө ч үнэлсээр буй. Харин орчин нөхцөл өөрчлөгджээ. Нэгэн үе улирахад 1 тэрбумаас олон хүн хурц хэлбэрийн ядуурлаас ангижирсан нь¹⁹ хүн төрөлхтний хамгийн агуу амжилтуудын нэг мөнөөс мөн. Гэвч Ковид-19 цар тахал 100 сая гаруй хүнийг хурц хэлбэрийн ядууралд оруулсан байж болзошгүй нь манай үеийн хамгийн том ухралт.²⁰ 2020 онд хүний хөгжил хүнд цочролд орлоо (зураг 4).²¹ Ядуурлын бүхий л хэлбэрийг арилгаж, хувьсан өөрчлөгдөж буй хөдөлгөөнт ертөнцийг ядуурлаас ангид байлгах нь гол зорилго мөн. Гэхдээ зорилгод хүрэх эрмэлзлэлийг цаг ямагт зохих ёсоор дэмжиж, энэ үйл явцад нэг ч хүнийг орхигдуулахгүй байхыг хичээх нь чухал. Хүний хөгжил бол эцсийн зогсоол биш, мөнхөд үргэлжлэх аялал юм. Гэхдээ гол цөм нь хүний үндсэн хэрэгцээг хангах төдийхнөөр хэзээ ч хязгаарлагдаж байгаагүй. Гол цөм нь эрх чөлөөг өргөжүүлж, хүмүүсийг өөрийн гэсэн утга учиртай амьдралын замналаа таньж, замнахад нь чадавхжуулах юм. Хүний хөгжлийн өнцгөөс хүн бол өвчтөн нь бус, гол цөм нь гэж үзэх нь энэ жилийн Илтгэлийн суурь сэдэв энэ болно.

Антропоценгийн үед биднийг түүхэнд байгаагүй сорилтуудтай нүүр тулах зуур орчин нөхцөл маань өөрчлөгдсөөр байна. Энэ удаад бид хүмүүсийн боломжит сонголтыг олшруулах буюу үнэ цэн өгдөг амьдралаараа амьдрах чадавхыг өргөжүүлэхийг дан ганц зорилгоо болгохгүй. Хүний хөгжлийн өөр хоёр чухал хэмжээсийг мөн нарийн авч үзэх ёстой. Тэдгээр нь: (1) чадамж (шийдвэр гаргалтад оролцох, өөрийн хүссэн сонголтыг хийх чадамж) ба (2) үнэт зүйл (хамгийн хүсэмжит сонголтуудаа хийх). Ингэхдээ байгальтай харьцах байдлаа онцгой анхаарч, эх дэлхийгээ сахин хамгаалах үүргээ умартаж болохгүй.

“Хүний хөгжлийн гол цөм нь эрх чөлөөг өргөжүүлж, хүмүүсийг өөрийн гэсэн утга учиртай амьдралын замналаа таньж, замнахад нь чадавхжуулах юм.


Антропоценгийн үед хүний хөгжлийн талаарх бидний эргэцүүлэлд хүний чадавх, чадамж болон үнэт зүйл бол гурван хөлтэй сандал мэт салгашгүй чухал юм. Хүмүүсийн чадавхыг нэмэгдүүлснээр эх дэлхийн дарамт аяндаа буурна гэж үзэж болохгүй. ХХИ-ээс үзэхэд харин ч яг эсрэгээрээ харагдаж байна. Хамгийн өндөр ХХИ-тэй улс орнууд гараг дэлхийдээ хамгийн өргөн цар хүрээнд, хамгийн их дарамт өгөх хандлагатай байна (зураг 5).

Зураг 4 Ковид-19 цар тахлын хүний хөгжилд учруулсан түүхэнд байгаагүй цочрол



Эх сурвалж: Эх сурвалж: НҮБХХ дэх Зураг 3-ын шинэчилсэн хувилбар (2020).

Зураг 5 Хүний хөгжил өндөртэй улс орнууд гараг дэлхийдээ илүү өргөн цар хүрээнд, илүү их ачаалал өгөх хандлагатай



Жич: Материалын үл мөр гэдэг нь аливаа улс орны бүтээгдэхүүн, үйлчилгээний дотоодын эцсийн хэрэгцээг хангахын тулд дотоодоос болон гадаадаас олборлон ашигласан материалын хэмжээг хэлдэг (биомасс, шатах ашигт малтмал, металлын хүдэр, металл бус хүдэр). Хөөсний хэмжээ нь улс орны хүн амын тоотой пропорционал хамааралтай. Антропоценийн эрин үед хүний хөгжлийн аяллаар хүрэх учиртай, одоогоор хоосон буй эцсийн зогсоолыг баруун доод буланд ногоон дөрвөлжингөөр тэмдэглэв (Шигтгээ 1-ийг үзнэ үү).
Эх сурвалж: НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн өгөгдөлд үндэслэн Хүний Хөгжлийн Илтгэлийн Албанаас (ХХИА) мэдээлэв.

Түүнчлэн, дан ганц бие даасан байх чадамжийг нэмэгдүүлснээр илүү олон чадавхажсан хүмүүс дангаар болон хамтран эх дэлхийн аюулт өөрчлөлтөөс зайлсхийх сонголтыг гарцаагүй хийнэ гэж үзэж болохгүй. Чадавхажсан хүмүүсийн амьдралдаа хийдэг сонголтыг ерөнхийд нь чиглүүлж байгаа гол хүчин зүйл нь үнэт зүйл, ялангуяа үнэт зүйлсийн хоршил ба харилцан үйлчлэл байв. Сайхан амьдрах гэдгийг бид хувьдаа хэрхэн ойлгодог вэ гэдэг нь бидний үнэт зүйлсээс голчлон хамаардаг. Гэхдээ хүмүүс хангалттай чадавх болон тусгаар үйлийн чадамжгүйгээр үнэт зүйлсээ ойлгож чадахгүй.

Энэхүү Илтгэлд хүн төрөлхтөн Антропоценийн эрин үед аж төрөхийн тулд эрх тэгш байдлыг нэмэгдүүлж, инновацыг дэмжиж, байгалиа хайрлан хамгаалах дадлыг төлөвшүүлснээр үйлдэл хийх чадавх, тусгаар үйлийн чадамж болон үнэт зүйлсийг хөгжүүлж чадна гэж үзсэн.²² Эдгээр нь хүмүүсийн өөрсдөдөө бүтээдэг, өсөн нэмэгдсээр буй сонголтын багцад зонхилох хэмжээтэй байж чадвал, өөрөөр хэлбэл тэгш байдал, инновац болон хайрлан хамгаалах зан үйл нь сайхан амьдралын гол цөм гэж ойлгогдож чадвал, эх дэлхийдээ өгч буй дарамт буурч, хүн төрөлхтөн ч цэцэглэн хөгжиж чадна.²³

Үнэт зүйлийг зориудаар, харьцангуй богино хугацаанд өөрчилж болдгийг нотолсон хангалттай нотолгоо бий. Тухайлбал, тамхитай холбоотой нийгмийн хэм хэмжээ, зохицуулалт болон зан үйлийн өөрчлөлт олон оронд өргөн хүрээнд өрнөсөн.²⁴ Саяхныг хүртэл дэлхийн олон оронд тамхи татах нь соёлын нэгэн хүсэмжит хэлбэр байсан. Харин сүүлийн хэдэн арван жилд тамхи татах нь хор хөнөөлтэй гэдгийг улс орнууд янз бүрийн түвшинд ойлгож эхэлсэн юм. Гэхдээ тамхины хэрэглээ, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд харьцангуй их байгаа нь асуудлыг шийдвэрлэхэд хийх ажил их хэвээр байна.²⁵ Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын ивээл дор батлагдсан анхны олон улсын эрүүл мэндийн хэлэлцээр буюу Тамхины Хяналтын Суурь Конвенц нь тамхийг хянах гол зорилготой юм. Дэлхийн хүн амын 90 гаруй хувийг хамарч, 182 улс нэгдсэн уг хэлэлцээр нь шинжлэх ухаанд суурилсан нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, улс төрийн тогтвортой, үр дүнтэй манлайллаар дэлхий нийтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж болдгийг харуулсан тод жишээ болсон юм.²⁶

“Тэгш байдал, инновац болон хайрлан хамгаалах зан үйл нь сайхан амьдралын гол цөм гэж ойлгогдож чадвал, эх дэлхийдээ өгч буй дарамт буурч, хүн төрөлхтөн ч цэцэглэн хөгжиж чадна.

Хүрээлэн буй орчны үнэт зүйлсэд ч мөн адил огцом өөрчлөлт гарсан юм.

Жишээ нь, Rachel Carson-ын *Silent Spring* гэх алдарт бүтээлийг олон зууны өмнөөс улбаатай, орчин цагийн байгаль хамгаалах хөдөлгөөний үүсгэл болсон гэж үздэг.²⁷ Байгаль орчны тэгш ёсны хөдөлгөөний тэргүүн шугамд төд удалгүй хуваарилалтын асуудал гарч ирсэн юм. Энэ хоёр аль аль нь түүхэнд байгаагүй хэлбэр, хэмжээгээр бий болж, эмзэг бүлгийнхэнд илүүтэй хурцаар нөлөөлж эхэлсэн агаарын бохирдол, усны бохирдол зэрэг шинэ бодит байдалд гаргасан томоохон практик хариу үйлдэл юм. Аль аль нь байгаль орчноо хайрлан хамгаалах зан үйл, нийгмийн тэгш ёс, үе хоорондын хариуцлагыг үүсгэж, сайхан амьдралын талаарх ойлголтыг өргөжүүлж, тогтвортой хөгжлийн эрин үеийн суурийг тавьсан билээ. Иймд, аль аль нь анх үүсэхдээ шийдвэрлэх зорилгод нь багтаагүй байсан гараг дэлхийн шинэ сорилтуудыг дагаад хувьсан өөрчлөгдсөөр байх ёстой.

Өнөөгийн Антропоценийн эрин үед хүмүүс ба эх дэлхийг салангид байдлаар авч үзэх явдлыг нэг мөр зогсоох нь нэн чухал байна. Дэлхийг нэгэн тогтолцоо гэж авч үзэх аргачлал нь бидний харилцан хамааралтай байдлыг нийгэм-экологийн систем бөгөөд Антропоценийн эрин үед асар чухалд тооцогдох ойлголт байдлаар тодорхойлж байна.²⁸

Хүний хөгжил нь ийм төрлийн сэтгэлгээтэй сайн нийцдэг. Хүний хөгжил цаг ямагт ангид тусдаа байдлыг арилгаж, харилцаа холбоог нэмэгдүүлэхийг зорьж байсан. Хүний боломжийг нэмэгдүүлэх зорилготой хөгжлийн чиг хандлага үүнээс өөрөөр байх боломжтой гэж үү? Хүн бүр нийгмийн, эдийн засгийн болон байгаль орчны хүрээлэлд орж, гарч аж төрдөг билээ. Фермер хүн нэг өдөрт эцэг эх байх, эхнэр нөхөр байх, түлээ түүх, ус авах, цаг агаар болон хортон шавжийн талаар санаа зовох, худалдан авах хэлэлцээр хийх, эм тан, сурах бичиг авах зэргээр олон үүрэг гүйцэтгэдэг. Хүн, газар болон байгаль орчин зөвхөн хөдөө орон нутагт харилцан холбогддог юм биш. Хотын оршин суугчид ч гэсэн байгаль орчинтойгоо холбогддог. Ихэвчлэн илүү өргөн эсвэл олон талт байдлаар хүнс, ус, агаар, амралт, сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийнхээ төлөө холбогдож байдаг. Хүний хөгжлийн аргачлал нь салбарлан байгуулагдсан институцийн бүтцээс илүүтэй аливаа хувь хүний туршлагад ач холбогдол өгдөг. Иймд салбар дагнаж, явцуурдаггүй. Хөгжлийг ямар ч хүний хардаг шигээр харахыг зорьдог.

Бидний улам бүр анзаарч байгаа тогтолцооны түвшний хямрал нь энэхүү аюулын дохио үүсэх болсон шалтгаан юм (2-р бүлэг). Асуудлуудыг ангид эсвэл хамаарал үгүй байдлаар, өөрийн гэсэн нийгэм, экологийн салангид нөхцөлд нь шийдвэрлэх боломжгүй болжээ. Угтаа хэзээд боломжгүй байсан биз. Өнөөгийн асуудлууд бол бүхэлдээ улаанаар анивчиж буй харилцан хамааралтай нийгэм-экологийн сүлжээн дэх зангилаанууд юм.²⁹

Энэ нийт систем, тогтолцооны тогтвортой байх чадавх, дасан зохицох, уян хатан чадвартай тэсвэртэй байдалд, ялангуяа, системийн нэг хэсэг тодорхой агшинд хүндрэлт орсон үед ч маш чухал гэдгийг хүлээн зөвшөөрөөд байна.³⁰ Дэлхий дахиныг нягт хэрсэн өнөө цагийн үйлдвэрлэл, хэрэглээний зонхилох загваруудын ижилсүүлэх үр нөлөө нь, тэсвэртэй байдалд амин чухал байдаг биологийн, соёлын зэрэг бүх төрлийн олон янз байдлыг үгүй хийжээ.³¹ Олон янз байдал нь давхцалыг нэмэгдүүлдэг. Давхцал нь бизнест ашиггүй ч, үндэстэн дамнасан цочролын үед тогтолцооны тэсвэртэй байдлыг нэмэгдүүлдэг.³²

“ Антропоценийн эрин үед хүмүүс ба байгаль дэлхийг салангид байдлаар авч үзэх явдлыг нэг мөр зогсоох нь нэн чухал.

Сүүлийн арав гаруйхан жилийн хугацаанд өрнөсөн дэлхийн санхүүгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гарч буй хямрал, тэгш бус байдлын хямрал болон Ковид-19 цар тахлын хямрал бүгдээрээ систем тогтолцооны тэсвэртэй чанар доройтсон гэдгийг харууллаа. Гал унтраах л зориулалттай нэмэлт тогтолцоо дэндүү олон болжээ. Нэгэнт доройтсон холбоосууд хямрал тохиолдоход нугарахаасаа илүү нурж унахад бэлэн болж Эх Дэлхийн Тогтолцоог улам тогтворгүй болгож байна.³³ Үүний дүнд эдийн засгийн хямрал, байгаль орчны асуудал болон вирусийн дэгдэлт илүү хялбар газар авч, улс орнуудын хооронд биет хилийн зааг байгаа эсэхийг үл харгалзан саадгүй нэвтэрч, хүн төрөлхтнийг байгаль дэлхийгээс заагласан төсөөллийн хэрмийг улам бүр өндөрлөх болжээ.

Ер нь хуучин хэв маягаараа үргэлжлүүлэн аж төрөх боломжгүй болж байна. Хүний хөгжлийн ойлголт ч мөн адил цаг үеийнхээ сорилтуудыг дагаж, тасралтгүй шинэчлэгдэн хөгжих ёстой. Гэхдээ өнөөгийн олон сорилтод амин хэрэгтэй хэвээр байгаа суурь зарчмуудаа хаяна гэсэн үг биш. Харин түүн дээрээ суурилж, геологийн энэхүү үймээн хөдөлгөөнтэй эрин үед амжилттай аж төрнө гэсэн үг. Хүний хөгжлийн зорилго буюу хүмүүс өөрсдийн үнэ цэнэ өгдөг амьдралаараа амьдардаг байх нь чухал хэвээр байгаа. Өнөөгийн болон хожмын үеийн хүмүүс хуучин хэв маягаараа үргэлжлүүлэн аж төрөхөд амьдралынх нь сонголтууд олшрох бус, цөөрсөөр байвал бид эргээд энэ л зорилгоо санаж, бэрхшээлээ даван туулах боломжуудыг эрэлхийлэх нь зүйн хэрэг.

Эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулна гэдэг нь гараг дэлхийн шим мандал буюу бүхий л амьд зүйлс бидний үнэгүй мэт санаж хэрэглэдэг агаар зэрэг асар олон хэрэгцээт зүйлсийг маань бий болгож байдгийг ойлгохоос эхэлнэ. Үүнийг ойлгож чадвал шим мандлыг цөлмөн сүйтгэх бус, нөхөн сэргээх

учиртай нь тов тодорхой болно. Түүнчлэн, улс орнууд эрчим хүч болон материалыг хэрхэн ашиглаж байгааг ойлгох хэрэгтэй. Эрчим хүчний эх үүсвэрүүд ямар хэмжээнд нар шиг хязгааргүй сэргээгдэх вэ? Мөн, материалыг хаягдал, бохирдол болгож эргэлтээс гаргахгүйгээр ямар хэмжээнд дахин боловсруулсаар байж болох вэ? Агаар мандалд нүүрстөрөгчийн давхар исэл нэмэгдсээр, далай тэнгист хуванцар хаягдал ихэссээр байна. Энэ нь шатах ашигт малтмалд түшиглэсэн, материалын хэрэглээний задгай циклтэй өнөөгийн хөгжлийн чиг хандлагаас үүдэн гарч буй эрсдэлүүдийг илтгэх олон жишээний наад зах нь юм. Биологийн олон янз байдлын доройтол ч мөн адил нэгэн жишээ. Үүнтэй төстэй нэг жишээ гэвэл улс орнуудыг соёлын хувьд ядууруулж байдаг хэл, соёлын олон янз байдал алдагдаж байгааг нэрлэж болно.³⁴

Эх дэлхий маань шинэ төлөвт шилжихийн өмнө тогтворгүй үеийг туулдаг. Гараг дэлхийн хэмжээний үйл явц ихэвчлэн бидний төрөл зүйлийн мэдлээс хэтийдсэн олон зуун мянга эсвэл олон сая жил үргэлжилдэг. Бидний хувьд эртний гэдгийг мянга мянган жилээр тоолдог бөгөөд хүн төрөлхтний мэдэгдэж буй түүх тэрхүү геологийн асар урт цаг хугацааны ганцхан агшинтай тэнцэхүйц богинохон билээ. Ярвигтай асуудлууд бол уур амьсгалын тогтворгүй байдлын дохио. Харьцангуй тогтвортой Холоценийн эрин үе бол өөрчлөгдөн буй уур амьсгалын тогтолцоон дахь мөстлөгийн сэрүүн үе болон дулаан үе хоорондын хэлбэлзэл илүү далайцтай болсон нэгэн дулаахан зурвас юм. Дэлхийн уур амьсгал хэдийн огцом өөрчлөгдөж эхэлсэн бол хүлэмжийн хийн ялгаруулалт, материалын циклийн тогтворгүй байдал зэрэг хүний нөлөөтэй гарч ирсэн гараг дэлхийн өөрчлөлтүүд нь гал дээр тос нэмсэн хэрэг болж, өмнө байсан тогтворгүй байдлыг улам бүр дэвэргэнэ гэсэн үг.

Энэхүү Илтгэлээр Эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулангаа хүний эрх чөлөөт байдлыг өргөжүүлэх өөрчлөлтөд уриалж байна. Илтгэлд орсон зөвлөмжүүд нь өөрчлөлтийг хийх хүмүүст бус, өөрчлөлтийг бий болгох механизм буюу (1) нийгмийн хэм хэмжээ ба үнэт зүйл; (2) хөшүүрэг ба зохицуулалт; мөн (3) байгальд суурилсан шийдэлд чиглэсэн болно. Энэхүү өөрчлөлтийн механизм тус бүр нь Засгийн газар, санхүүгийн зах зээл, улс төрийн болон иргэний нийгмийн манлайлагчид зэрэг оролцогч тал бүрд өөр өөрийн гэсэн олон талт үүргийг тодорхойлж өгч байгаа юм. Хүн эсвэл мод гэж аль нэгийг нь сонгох мөн алдаа гаргадаг гэсэн шалтгаанаар зах зээлийн харилцааг үгүйсгэх нь зүйд нийцэхгүй. Харин хэм хэмжээ ба үнэт зүйл, хөшүүрэг ба зохицуулалт, Байгальд суурилсан шийдэл зэрэг өөр өөр аргачлалыг хамтатган ашиглаж, Эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулангаа хүний хөгжлийг дэмжих нь зөв зам юм.

Системтэй болон олон ургальч сэтгэлгээ нь

нийгмийн хэм хэмжээнд нэгэн адил хамаарна. Нийгмийн хэм хэмжээг хүүхдүүд сургуульдаа юу сурах, хүмүүс онлайнд юу хийх, удирдагчид юуг ярьж, бодлогоор хэрэгжүүлэх зэргээс үүдэн нийгэм даяараа үүсгэж, бэхжүүлж байдаг. Хэм хэмжээ нь тогтвортой бөгөөд тэсвэртэй шинж чанарыг үзүүлдэг ч, чухал үеүдэд заримдаа хүмүүсийн хүслээр, заримдаа хүмүүсийг хүсээгүй байхад шинэ шатанд гарахаас өөр аргагүй шахалт, сорилгод ордог. Эерэг эгэх мэдээллийн холбоо нь өөрчлөлтийг хурдасгаж, шинэ хэм хэмжээг тогтворжуулахад тусалдаг. Тамхи татах тухайд гарсан хэм хэмжээ өөрчлөгдсөн шиг өөрчлөлт заримдаа асар богино хугацаанд өрнөдөг. Гэхдээ мэдээж, өөрчлөлт эргэж буцах боломжтой. Хөшингө бөгөөд хүчирхэг хэм хэмжээ гээч зүйл хэрхэн өөрчлөгддөг вэ? Бодлого боловсруулагчид болон энгийн иргэдэд ямар хөшүүрэг, механизм байна вэ? Энэ асуулт энэ Илтгэлийн 4-р бүлгийн суурь болно. Нэгдүгээр алхам бол хүмүүст буй боломжит сонголтыг нэмэгдүүлэх. Эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэр болон олон загварт тээврийн сүлжээ зэргээр сонголтыг олшруулах нь хүмүүст үнэт зүйлээ ойлгоход нь тусална. Түүнчлэн өрсөлдөөнтэй, сайн ажиллагаатай зах зээлийг бий болгоход тусална.

“Энэхүү Илтгэлээр Эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулахын зэрэгцээ хүний эрх чөлөөг нэмэгдүүлсэн томоохон өөрчлөлтөд уриалж байна.

Үүнтэй зэрэгцээд, хямралын цаг үе аливаа тогтолцоог чухал өөрчлөлтийн босгонд авчирдаг. Жишээ нь, Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын нэг болох хүн бүрд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх зорилгод хүрсэн улс орнуудын амжилтын түүх байна. Саяхны судалгаанаас үзэхэд өөр өөр орлогын түвшинтэй 49 улс орноос ихэнх нь нийгмийн байгууллын өөрчлөлтийг туулж, тогтвортой байдал руу ойртсоны дүнд хүн бүрд хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох зорилгодоо ойртож чадсан байна.³⁵ Түүнчлэн хөрш зэргэлдээ эсвэл ижил түвшний бусад орнууд нь энэ зорилгод хүрсэн байвал тухайн орон өөрсдийн иргэн бүрд хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг илүү хялбар нэвтрүүлж байжээ. Энэ нь хөшүүрэг болон эерэг эгэх мэдээллийн холбооны үр нөлөө юм. Бидний туулж буй хямралууд болон улам бүр хурцдаж байгаа Ковид-19 цар тахал нь улс орнуудад нийгмийн хэм хэмжээгээ дахин үнэлэх, бодлого боловсруулагчдад илүү эрүүл, илүү ногоон, илүү тэгш ирээдүйд хөрөнгө оруулах замаар нийгэм, эдийн засгаа сэргээн босгох чиглэлд зоримог алхам хийх боломжийг олгож, байгаль дэлхийн дарамтыг бууруулангаа хүний эрх чөлөөг өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Өнөө үед дэлхийн хүн амын бараг 80 хувь нь эх дэлхийгээ хамгаалах нь чухал гэж үздэг болжээ. Гэвч дөнгөж тал орчим хувь нь эх дэлхийгээ


хамгаалахын тулд шийдвэртэй алхам хийхэд бэлэн байгаа юм. Хүмүүсийн үнэт зүйл болон зан үйлийн хооронд зааг байна (4-р бүлгийг үзнэ үү). Уг заагийг арилгаж, хүмүүсийг чадавхжуулахын тулд энэхүү Илтгэлд хүмүүсийг итгэл үнэмшлээрээ үйлдэл хийх, эс хийхэд нь урамшуулан дэмжих хөшүүргийг бий болгох талаар өгүүлсэн (5-р бүлэг). Хувь хүмүүс үзэл бодол, үнэт зүйлсээ өөрчлөхгүй байсан ч урамшуулан дэмжих арга үр дүнгээ өгдөг. Шатах ашигт малтмалын татаасыг зогсоож, нүүрстөрөгчийн татвар тогтоох зэргэ хөшүүргийн механизмыг хэрэгжүүлснээр бид эх дэлхий болон нийгмийн тэнцвэргүй байдалд хүргэж буй өнөөгийн хэрэглээ, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт болон бусад сонголтын ерөнхий зураглалыг ойлгох болно. Тухайлбал, шатах ашигт малтмалын татааснаас үүдэж, жил бүр 5 их наяд ам долларын шууд болон шууд бус зардал гардаг. Эдгээр татаасыг 2015 онд бүрэн зогсоосон бол дэлхийн нүүрстөрөгчийн ялгаруулалтыг 28 хувиар, шатах ашигт малтмалаас улбаатай агаарын бохирдлын шалтгаант нас баралтыг 46 хувиар бууруулах байв.³⁶

Антропоценийн эрин үед дэлхийн дарамтыг бууруулж, хүний хөгжлийг ахиулахад шаардлагатай томоохон өөрчлөлтөд нийгмийг хөтлөхөд урамшуулал, хөшүүргийн механизмыг хэрхэн ашиглах талаар энэхүү Илтгэлд тайлбарласан байгаа. Ингэхдээ урамшуулал, хөшүүргээр хэлбэржүүлэн өөрчилж болох гурван талбарыг тодорхойлов. Нэгдүгээрт, санхүүгийн талбар. Санхүүгийн фирмүүд болон тэдний үйл ажиллагааг хянадаг зохицуулах байгууллагад зориулсан хөшүүргийн механизм бий болгох тухай авч үзэв. Хоёрдугаарт, өртөг үнийн талбар. Нийгмийн болон байгаль орчны өртгийг бүрэн тусгах нь ховор байдаг учраас энэ талбар зан үйлд нөлөөлсөөр байдаг. Гуравдугаарт, хамтын үйл ажиллагаанд зориулсан хөшүүрэг зохицуулалтын талаар олон улсын түвшинд авч үзлээ.

Байгальд суурилсан, байгальд ээлтэй хүний хөгжил нь Антропоценийн үед тулгарах гурван гол сорилт буюу (1) Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулж, дасан зохицох; (2) биологийн олон янз байдлыг хамгаалах; мөн (3) хүн бүрийг хүний сайн сайхан байдлаар хангах сорилтыг даван туулахад тусална. Байгальд суурилсан хүний хөгжил гэдэг нь хүмүүсийн чадамжийг гол цөмөө болгосон. Байгальд суурилсан шийдлийг бий болгох, системтэй аргачлалд тулгуурлан нийгмийн болон эдийн засгийн тогтолцоог хүний хөгжилтэй хамтатган, экосистем болон шим мандлын түвшинд авч үзэх энэ хөгжилд асар их боломж бий. Уур амьсгалын өөрчлөлтийг удаашруулж, гамшгийн эрсдэлийг бууруулахаас авхуулаад хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, усны хүртээмж ба чанарыг дээшлүүлэх хүртэлх олон үр ашгийг дагуулах болно. Дэлхийн ойн сан, намагшсан газар, тал хээр болон хөдөө аж ахуйн газруудыг хамруулсан өртгийн хэмнэлттэй 20 багц шийдлийг хэрэгжүүлбэл 2030 он гэхэд дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үеийн түвшнээс дээш 2 хэмээс бага байлгахад шаардлагатай нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилтын 37%-ыг, мөн 2050 он гэхэд хүрэх шаардлагатай байгаа бууруулалтын зорилтын 20%-ыг хангаж чадахаар

байна (зураг 6).³⁷ Энэхүү бууруулах боломжийн гуравны хоёр орчим нь (нийт бууруулах шаардлагын дөрөвний нэгийг бүрдүүлнэ) ойтой холбогдох ажил буюу голчлон ойжуулах ажилтай холбогдоно.

Зураг 6 Байгальд суурилсан 20 шийдэл нь дэлхийн дулаарлыг хязгаарлахад шаардлагатай бууруулалтын багагүй хувийг бий болгоно.



Эх сурвалж: Griscorn нар (2017).

Амазоны нэг уугуул иргэний ой хамгаалах үйл ажиллагаанаас Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад оруулж буй хувь нэмэр нь дэлхийн орлогын хуваарилалтын тэргүүлэх 1%-ийн төлөөлөл болсон нэг хүний ялгаруулсан бохирдолыг дүйцүүлэн саармагжуулж байна (6-р бүлгийг үзнэ үү).

“Байгальд суурилсан шийдэл” гэдэг нэр томьёо нь шийдэлд чиглэсэн хэллэгээс болж буруу ойлгогддог. Үнэндээ, Байгальд суурилсан шийдэл буюу аргачлал нь эрүүл экосистемээс хүмүүс болон байгаль дэлхийд ирэх олон үр ашиг, үнэт зүйлсийг таньсан нийгэм-экологийн тогтолцоонд хамаардаг. Гэвч уг үр ашиг нь нарийн цогц, олон талт байдаг учраас нийтлэг зүй тогтол бус, тухайн тохиолдлууд болж харагддаг. Эдийн засгийн уламжлалт хэмжүүрээр нийт үр ашгийг зөв тооцоход тун бэрх. Мөн үр ашиг нь хөдөө аж ахуй, байгаль орчин, зам тээвэр, дэд бүтэц, хөгжил, аялал жуулчлал, эрүүл мэнд, санхүү зэрэг тоо томшгүй яамдын хариуцах салбаруудад тархсан байгаа үед тооцоолоход туйлын бэрх. Иймд асуудлын гол нь Байгальд суурилсан шийдэлд бус, харин бидний голчлон ашигладаг хэмжүүрүүд болон засаглалын хэлбэрүүдийн хангалтгүй байдал оршиж байгаа бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхэд оролцох хүмүүсийн чадамжийн асуудлыг харгалзан үзэхгүй. Антропоценийн эринд амжилттай оршин тогтохын тулд дэлхий нийтээр хамтдаа сэтгэж, хамтдаа нэгдсэн бодлого боловсруулах нь улс орнуудын төдийгүй хүн төрөлхтөний хэм хэмжээ болох ёстой.

Энэхүү тайлан нь тухайлсан үйлдэгчид бус, аливаа үйл ажиллагааг хийж хэрэгжүүлэх механизмд төвлөрсөн. Энэ нь нэг талаараа Антропоценийн үеийн хүний хөгжил нь нийт нийгмийг бүхэлд нь авч үзэх арга хэмжээ шаардаж байгаатай холбоотой юм. Хэдий тийм боловч, нийгмийн системд оролцогч засгийн газар, тэр дундаа үндэсний засгийн газар манлайлалын чухал

үүрэг гүйцэтгэдэг. Зөвхөн үндэстэн улсуудын засгийн газруудад аливааг хэрэгжүүлэх албан ёсны эрх мэдэл оршиж хамтын сорилтын төлөөх нэгдмэл үйл ажиллагаануудыг эхлүүлэх, бүх нийтийн инновацыг дэмжих, хүч чадалтай байдаг. Тухайлбал, нүүрстөрөгчийн татвар тогтоох, нийгмийн зарим бүлгийг эмзэг эсвэл эрх хомс байдалд оруулах хуулиудыг цуцлах, төрийн хөрөнгө оруулалтаар бодлого, институцүүдийг бий болгох зэрэг болно. Эрх мэдэл нь хариуцлага болон эгэх хариуцлагатай хамт явдаг.

Гэхдээ энэ бүхнийг засгийн газрууд дангаараа хийж чадахгүй. Антропоценийн эрин үеийн сорилтууд нь дэндүү нарийн цогц учраас дан ганц бүхнийг чадагч эрх мэдэл эсвэл технологийн дэвшилтэт шийдлээр шийдэх боломжгүй юм. Доороос дээш чиглэсэн нийгмийн бүрэн оролцооны ач холбогдол, түүгээр нээх боломжуудыг үл хэрэгсэж болохгүй. Хувь хүмүүс, нийгэмлэгүүд болон нийгмийн хөдөлгөөнүүд засгийн газруудад шахалт, шаардлага, дэмжлэг үзүүлж, үйлдэлд хөтөлдөг. Гэхдээ засгийн газрын удирдлага болон үйл ажиллагаа нь дангаараа хангалтгүй боловч, шаардлагагүй гэсэн үг бас биш. Үлгэрлэн манлайлах нь чухал. Засгийн газрууд шатах ашигт малтмалд татаас олгосноороо эдийн засаг болон байгаль орчны илэрхий асуудлуудыг өргөн хүрээнд дэмжиж байгаагаа харуулдаг. Мөн үнэт зүйлсийн талаар хувирашгүй мессеж өгч байдаг. Чили, Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг хэд хэдэн орон саяхан нүүрстөрөгчийн ялгаруулалтаа зогсоох зоримог хөтөлбөр зарлаж, дээрхийн эсрэг чиглэлд хүчирхэг мессеж өгч чадсан билээ.³⁸ Европын Холбоо ч мөн адил хөтөлбөр баталсан.³⁹ Илүү олон улс орны хүчин чармайлт, түүнчлэн тогтвортой хөрөнгө оруулалтыг сонирхож эхэлж буй, байгаль орчны, нийгмийн болон засаглалын нөлөөллийг бодолцон үзсэн бизнесийн арга барил руу шилжиж буй хувийн хэвшлүүдийн хүчин чармайлтын үрээр Антропоценийн эрин үед хүний хөгжлийг ахиулахад шаардлагатай хэм хэмжээний өөрчлөлтийг хурдасгаж чадна.

Хөгжил хөдөлгөөнт (динамик) чанартай. Тэргүүлэх асуудлууд болон үнэт зүйлс нь өөрчлөгддөг. Иймд хэмжүүр нь ч мөн өөрчлөгдөх ёстой. Ийм учраас хүний хөгжлийн хэмжүүрийн багц үргэлж хувьсан хөгжиж ирсэн юм. Сүүлийн арван жилд мэдээллийн шинэ хянах самбарууд хийгээд жендэрийн тэгш бус байдал болон эмэгтэйчүүдийн чадавхжуулалтыг хэмжих зорилготой нийлмэл индексүүд бий болсон билээ. 2010 оны Хүний Хөгжлийн Илтгэлээс хойш Тэгш Бус Байдлыг Тооцсон ХХИ-ээр улс орнуудын хүний хөгжлийн тархцыг хэмжих болсон. Мөн Олон Хэмжээт Ядуурлын Индексийг дэлхий даяар нэвтрүүлж, уламжлалт, орлогод суурилсан ядуурлын хэмжилтээс илүү цогц, бодит ядуурлыг хэмжихэд анхаарах болсон юм.

ХХИ нь үндсэн багц чадавхыг хэмжихэд хэрэгтэй хэмжүүр хэвээр байгаа ч, бид энэ бүхнийг нэгэнт олон хэмжүүр ашиглан хэмждэг болсон билээ. Мэдээж, ХХИ-ээр хүний хөгжлийг бүрэн цогц илтгэж чадахгүй. Бидэнд тулгардаг сорилтууд болон бидний өмнө буй боломжууд үеийн үед нарийн цогц, асар олон талтай, харилцан нягт уялдаатай байсаар


ирсэн тул хэчнээн сайн байсан ч нэг эсвэл цөөн хэдэн хэмжүүрээр бүрэн хэмжих боломжгүй юм. Нарийн цогц байдал нь илүү нарийн оновчтой хэмжилт шаардана. Шинэ хэмжүүр нэвтрүүлснээр хэмжилтийг илүү нарийн оновчтой болгож чадна.

“Энэхүү Илтгэлд, геологийн шинэ эрин үед нийцүүлэн, ХХИ-ийг дэлхийд өгч буй дарамттай уялдуулан тооцож оруулав.

Энэ Илтгэл шинэ хэмжүүрээр юуг судлах вэ? Шинэ үеийн мэдээллийн хянах самбар болон шинэ хэмжүүр ашигласнаар ХХИ-ийн орлогын бүрэлдэхүүнийг нүүрстөрөгчийн нийгмийн өртөг эсвэл байгалийн баялагтай уялдуулан тооцож эхэлж байна.

Гэхдээ улс орнуудад хэм хэмжээ тогтоож, шүүн таслах зорилго агуулаагүй. Харин хүний хөгжлийн бусад бүх хэмжүүрийн нэгэн адил, улс орнуудад ахиц дэвшлээ урт хугацаанд судлах, бусад орны туршлагаас суралцах, хүмүүсийн эх дэлхийтэйгээ харилцах харилцааг тооцсон байдлаар хүний хөгжлөө ахиулах зорилго тавихад туслах болно. Мөн, өмнөө тавьсан зорилгынх нь хариуцлагыг улс орнуудаас шаардах боломжийг иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудад олгоно. Нийлмэл хэмжүүрүүд, ялангуяа олон улсын түвшний нийлмэл хэмжүүрүүд улс орны дотоодын ярвигтай асуудлуудыг тухайлан илрүүлж чаддаггүй ч, өргөн хүрээтэй, дээд түвшний чиг баримжаа өгдөг. Нийлмэл хэмжүүр нь улс орон болгонд өрнөж байдаг цогц хэлэлцүүлэг, бодлого боловсруулах үйл явцыг орлохгүй ч, хувь нэмэр болж чадна.

Зураг7 Стандарт Хүний Хөгжлийн Индексийн тоон утгыг эх дэлхийдээ өгч буй дарамттай уялдуулан тооцоход хүний хөгжлийн түвшин өндөр байх тусам ДДТХХИ нь буурч байна.



Эх сурвалж: Хүний Хөгжлийн Илтгэлийн Алба (ХХИА).

Шигтгээ 1 Дэлхийн Дарамтыг Тооцсон ХХИ: Антропоценийн эрин үед амьдрах замын тэмдэг


ДДТХХИ нь дэлхийн дарамтыг бууруулангаа хүний хөгжлийг ахиулах замыг чиглүүлэх хэмжүүр бөгөөд хүний хөгжлийг дэлхийн дарамтын үзүүлэлтүүдтэй уялдуулан авч үзэх замаар өнөөг хүртэл эзэнгүй байсан “хоосон булан” руу хөтөлнө (зураг 5-д буй ногоон дөрвөлжин).¹ Доорх зурагт хэвтээ тэнхлэг нь ХХИ-ийн тоон утга, босоо

тэнхлэг нь эх дэлхийд өгч буй дарамтын индексийг илтгэнэ.² Ижил өнгөөр будсан талбайнууд нь ДДТХХИ -ийн нэгэн ижил тоон утгыг илтгэх ба үүнийг ХХИ-ийн тоон утгууд болон эх дэлхийд өгч буй дарамтын индексийн тоон утгуудын янз бүрийн хослолоор тооцож гаргадаг. Дарамтын муруй баруун доод булан руу дөхөх тусам ДДТХХИ -ийн тоон утга нэмэгдэнэ. ДДТХХИ -ийн тоон утга өндөр байна гэдэг нь хүний чадавхыг нэмэгдүүлсэн, дэлхийд учруулах дарамт багатай хүний хөгжил гэсэн үг. Ногоон өнгөөр будсан баруун доод булан бол Антропоценийн эрин үед хүний хөгжлийн аяллын хүрэхийг зорих учиртай эцсийн зогсоол юм.³ Гэвч энэ аялал дэндүү удаан, идэвх сул явж ирлээ. Цаашид ахиц дэвшилтэй байхын бүх улс орон бүр баруун доод булан руу нэн яаралтай, өргөн далайцтай тэмүүлэх шаардлагатай байна. ДДТХХИ болон ХХИ нь бид бүгдэд Антропоценийн эрин үед дэлхийн дарамтыг бууруулангаа хүний хөгжлийг ахиулах аяллаа үнэлэх, улмаар зөв сонголтуудыг хийхэд тусалж чадна.

Эх дэлхийд өгч буй дарамтыг бууруулангаа хүний хөгжлийг ахиулах чиглэлд улс орнууд дэндүү удаан явж байна.

Үр дүн сайжирсан байдал: 1990 он ба 2019 он

— Дарамтын муруй 1990 — Дарамтын муруй 2019



Жич: 1990 болон 2019 оны салбар дамнанас дарамтын хэв шинжийг полиномиал регрессийн загвар ашиглан тооцов. Сүүдэрлэн будсан талбай нь итгэлтэй интервал болно.

Эх сурвалж: Хүний Хөгжлийн Илтгэлийн Алба (ХХИА).

Зүүлт:

1. Lin нарын (2018) судалгаан дахь адил төстэй дүн шинжилгээг үзнэ үү. Энэ санаа, хөгжлийн тэмүүлж буй талбарын зураглал болохын хувьд, Fajnzylber-ийн “casillero vasco” гэх санаатай (1990) төстэй байгаа юм. 2. Дэлхийн дарамтыг тооцох итгэлцүүрийг нэгээс хасаад ХХИ-ээр үржүүлбэл ДДТХХИ гарна. 3. Энэхүү графикийг байгуулахад тусалсан Marina Fischer-Kowalski-д талархал илэрхийлье.

Энэхүү Илтгэлд ХХИ-ийг дэлхийд өгч буй дарамттай уялдуулан тооцож оруулав. Эх дэлхийд өгч буй Дарамтыг Тооцсон ХХИ (ДДТХХИ) нь анхны ХХИ шиг энгийн бөгөөд тодорхой байхын зэрэгцээ Илтгэлийн туршид хэлэлцсэн нарийн төвөгтэй, тогтолцооны түвшний хөдөлгөөнт чанарыг мөн тооцож үзсэн болно. Дэлхийд өгч буй голлох дарамтыг тооцсоноороо энэхүү индекс нь ХХИ-ийг геологийн шинэ эрин үед нийцүүлж байна.

“Эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулахын зэрэгцээ чадавхад суурилсан хүний хөгжлөө өргөжүүлэх олон боломж улс орнуудад байна. Бие даасан байдал болон үнэт зүйлийг мөн чухалчлан үзвэл энэ боломж улам бүр нэмэгдэнэ.

ДДТХХИ нь стандарт ХХИ-ийг тухайн улсын нэг хүнд ногдох нүүрстөрөгчийн давхар исэл ялгаруулалт болон материалын ул мөрийн түвшинтэй уялдуулан тооцдог. Хүний хөгжлөөр доогуур жагсдаг улс орнуудын хувьд энэхүү ачааллын тооцооноос үүдэх эрэмбийн өөрчлөлт ерөнхийдөө бага байна. Өндөр эсвэл маш өндөр хүний хөгжилтэй улс орнуудын хувьд эрэмбийн өөрчлөлт нэлээн их байх бөгөөд хөгжлийн замнал нь эх дэлхийд маань хэрхэн нөлөөлж байгааг тод томруунаар харуулах юм (зураг 7 ба шигтгээ 1).

Эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулахын зэрэгцээ уламжлалт, чадавхад суурилсан хүний хөгжлийн ойлголтоо хадгалах, бүр өргөжүүлэх олон сонголт, боломж улс орнуудад байгаа нь олзуурхуштай.

Энэ Илтгэлд тайлбарласан чадамж болон үнэт зүйлийг мөн чухалчлан үзвэл Эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулангаа хүний эрх чөлөөг өргөжүүлэх боломж улам бүр нэмэгдэнэ.

Альбер Камю дайны дараах алдарт *Тахал* хэмээх зохиолдоо, “энэ тахал хүн бүрийн дотор бий. Учир нь энэ хорвоо дээр дархлаатай хүн нэгээхэн ч үгүй”⁴⁰ гэж бичжээ. Тэрбээр өдгөө ч зохиол бүтээл туурвисаар байсан бол Ковид-19 эсвэл уур амьсгалын өөрчлөлтийн асуудлын талаар уран бүтээл туурвисаар байх байсан биз. Мэдээж, эдгээр гамшигт хүн бүр өртдөг ч, харилцан адил өртдөггүй гэдгийг бид ойлгох болсон. Хүн төрөлхтөн тахалд нэрвэгдэх эрсдэл 70 жилийн өмнөхөөс хол илүү нэмэгдсэн байж болох ч, бид тахлыг ч, хөгжлийг ч гар хумхин хүлээх шаардлагагүй гэдгээ ойлгож чадвал итгэл найдварын гэрэл бөхөхгүй. Бидний хувь заяа өөрийн эрхгүй сонголтоос хамаарахаар болсон байна. Харин сонголт нь эрх мэдэлд суурилж байна. Антропоцен гэх энэхүү геологийн нэн шинэ эринд – хүн төрөлхтний эринд – зөвхөн хүний төрөл зүйлд л эх дэлхийгээ дахин загварчилж, сэргээн хөгжүүлэх эрх мэдэл хийгээд тэгш ёс болон тогтвортой байдлыг сонгох боломж байна. Дэлхий дахиныг хамарсан олон төрлийн хямралд нэрвэгдсэн нэгэн оны төгсгөлд нийтлэгдэж буй энэхүү 2020 оны Хүний Хөгжлийн Илтгэл бидэнд энэ зам дээр зүг чигээ олоход тусална.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын

Хөгжлийн Хөтөлбөр

Нэгдсэн Үндэстний Плаза, Нью-Йорк хот,

NY 10017

www.undp.org

Бид эх дэлхийн ирээдүйд хүн төрөлхтөн голлон нөлөөлдөг Антропоцен хэмээх геологийн шинэ эрин үед хөл тавьж байна гэж хэлж болно. Эх дэлхийн ирээдүй Уур амьсгалын өөрчлөлтөөс авхуулаад биологийн олон янзат байдлын доройтол, далайн хуванцар хог хаягдлын гамшиг зэргээр олон талт аюул дохиолж байна.

Эх дэлхийд маань учраад буй энэхүү дарамт нь олон оронд учирч буй сорилтуудын толин тусгал юм. Мэдээж, эх дэлхийн болон нийгмийн тэнцвэргүй байдал харилцан бие биенээ дэвэргэдэг. 2019 оны Хүний Хөгжлийн Илтгэлд илт өгүүлсэнчлэн хүний хөгжлийн олон талт тэгш бус байдал өссөөр байгаа бөгөөд цаашид ч өснө. Гараг дэлхийн олон аюулт өөрчлөлтийн дундаас Уур амьсгалын өөрчлөлт уг тэгш бус байдлыг улам дордуулна.

Өргөн тархсан тэнцвэргүй байдлын хамгийн сүүлийн үеийн хор уршиг Ковид-19 цар тахлаар илэрч байна. Хүн, амьтан, зэрлэг байгалийн харилцаа нэмэгдсээр, эцэстээ экосистемүүдэд асар их ачаалал үүсгэж, шинэ төрлийн өвчин үүсгэгч вирус дэгдэнэ хэмээн эрдэмтэд олон жил анхааруулж байсан билээ. Нийгмийн хуваагдал их байгаа энэ нөхцөлд Ковид-19 цар тахлаас авхуулаад Уур амьсгалын өөрчлөлт хүртэлх аливаа асуудалд нэгдмэл арга хэмжээ авахад улам бүр хэцүү болж байна.

Ухамсартай ч бай, үгүй ч бай, үнэт зүйлс болон институтүүдийн нөлөөнд хийсэн хүн төрөлхтний сонголтууд нь өнөө бидний өмнө тулгамдаад буй эх дэлхий болон нийгмийн харилцан уялдаатай тэнцвэргүй байдлыг бий болгожээ. Гэхдээ бидэнд одоог хүртэл хийсээр ирсэн сонголтуудаа өөрчлөх боломж байгаа нь олзуурхууштай. Бидэнд эх дэлхийтэйгээ тэнцвэртэй байдлаар хүний хөгжлийг өргөжүүлсээр байх хөгжлийн зоримог шинэ замыг сонгох эрх мэдэл бий.

